



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар A/510

Улаанбаатар хот

「Баянзүрх дүүргийн “Хасагт эрдэнэ” өрхийн
эрүүл мэндийн төвийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны A/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дезерет олон улсын байгууллагаас хандивласан нийт 3,775,000.0 (гурван сая долоон зуун далан таван мянга) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Баянзүрх дүүргийн “Хасагт эрдэнэ” өрхийн эрүүл мэндийн төв (Б.Туул)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн “Хасагт эрдэнэ” өрхийн эрүүл мэндийн төв (Б.Туул)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын оны дугаар сарын-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн "Хасагт эрдэнэ" өрхийн эрүүл мэндийн төв

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлд авах		Эх үүсвэрээр
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	
1	Нярайн жин	Baby Scale BУBO1		2024	шинэ	ш	1	160,000.0	160,000.0	Дээрэт олон улсын энэрлийн байгууллага
2	Нярайн шарлалт хэмжигч аппарат	ВУ-D-1	Хятад	2024	шинэ	ш	1	3,500,000.0	3,500,000.0	
3	Чихний отоскопи			2024	шинэ	ш	1	115,000.0	115,000.0	
	Нийт бүртгэх хөрөнгийн дүн								3,775,000.0	Хандив